



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, төлбөр  
тооцоог гүйцэтгэхэд баримтлах  
журамд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 59 дугаар “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иар гүйцэтгүүлэх тухай” тогтоол, компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.26 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 19 дүгээр тогтоолын Дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам”-д холбогдох байгууллагуудаас ирүүлсэн санал, чиглэлийг харгалзан дор дурдсан өөрчлөлт оруулсугай. Үүнд:
  - 1). Журмын 7 дугаар зүйлийн 7.11 дэх хэсэгт “ Энэхүү журмыг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл дагаж мөрдөнө” гэснийг хасах.
2. Журамд оруулсан өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж, зөвшөөрөл авахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолоор журамд оруулсан өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрсөн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
4. Энэхүү тогтоолоор журамд оруулсан өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрсөн өдрөөс эхлэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд оролцогчдод нэн даруй танилцуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1524010081



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

### Гишүүнээр элсүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.20, Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Өлзий энд ко капитал ҮЦК” ХХК-ийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах гишүүн брокероор элсүүлсүгэй.
2. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын дагуу “Өлзий энд ко капитал ҮЦК” ХХК-тай “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ” байгуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.
3. Үнэт цаас, уул уурхайн биржийн зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг “Өлзий энд ко капитал ҮЦК” ХХК (Б.Өлзийбаяр)-д үүрэг болгосугай.
4. Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын системийн хөгжүүлэлт болон арилжаа эрхлэгч байгууллагын системтэй шаардлагатай холболтыг бүрэн хийж дуусгахыг “Өлзий энд ко капитал ҮЦК” ХХК (Б.Өлзийбаяр)-д даалгасугай.
5. Хууль тогтоомж болон зах зээлд мөрдөгдөж буй журам, заавар, гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн гишүүн компанийн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1524010088





## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

### Гишүүнээр элсүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.20, Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Коммодити трэйд маркетс” ХХК-ийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах гишүүн брокероор элсүүлсүгэй.
2. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын дагуу “Коммодити трэйд маркетс” ХХК-тай “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ” байгуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.
3. Үнэт цаас, уул уурхайн биржийн зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг “Коммодити трэйд маркетс” ХХК (Т.Тайванбаяр)-д үүрэг болгосугай.
4. Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын системийн хөгжүүлэлт болон арилжаа эрхлэгч байгууллагын системтэй шаардлагатай холболтыг бүрэн хийж дуусгахыг “Коммодити трэйд маркетс” ХХК (Т.Тайванбаяр)-д даалгасугай.
5. Хууль тогтоомж болон зах зээлд мөрдөгдөж буй журам, заавар, гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн гишүүн компанийн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1524010086



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

### Гишүүнээр элсүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.20, Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Апекс капитал ҮЦК” ХХК-ийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах гишүүн брокероор элсүүлсүгэй.
2. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын дагуу “Апекс капитал ҮЦК” ХХК-тай “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ” байгуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.
3. Үнэт цаас, уул уурхайн биржийн зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг “Апекс капитал ҮЦК” ХХК (Б.Лхамдолгор)-д үүрэг болгосугай.
4. Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын системийн хөгжүүлэлт болон арилжаа эрхлэгч байгууллагын системтэй шаардлагатай холболтыг бүрэн хийж дуусгахыг “Апекс капитал ҮЦК” ХХК (Б.Лхамдолгор)-д даалгасугай.
5. Хууль тогтоомж болон зах зээлд мөрдөгдөж буй журам, заавар, гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн гишүүн компанийн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1524010084





## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

### Гишүүнчлэлээс хасах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дах заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.6 дахь заалт, “Гишүүнчлэлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.5.3, 5.5 дахь хэсгүүд, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.20 дах заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 123 дугаар тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 13-ний өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Гэрэлт ассэймоор капитал ҮЦК” ХХК-ийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнчлэлээс хассугай.
2. Гишүүнчлэлээс хассантай холбогдуулан мэдээллийн санд зохих өөрчлөлт оруулах, олон нийтэд мэдээлэх, холбогдох мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-д тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1524010082